



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/65

Хэрлэн сум


Хөтөлбөр хэрэгжүүлэхэд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Хүүдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хорин гуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төр-Иргэний нийгмийн байгууллагаар төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх зорилгоор "Итгэл төгс нөмөр сан" төрийн бус байгууллагаар "Ид шидийн орон Хэнтий" төслийг хэрэгжүүлэхэд ажил гүйцэтгэх гэрээний дагуу 12,937,500 (арван хоёр сая есөн зуун гучин долоон мянга таван зуун) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний "Хүүхдэд ээлтэй орон нутаг болно зардал"-аас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ